



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/919

Мандалговь

Эзэмшил газрын хэмжээг өөрчилж,
нэгж талбарыг нэгтгэх тухай


Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дахь заалт, 31 дугаар зүйлийн 31.3 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.1.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт (Бага тойруу-4-4106 тоот) байршилтай иргэн Сайнхүүгийн Батсүх (ЗИ:92063014)-ийн худалдаа үйлчилгээний зориулалттай 320 м.кв (0.03га) эзэмшил газар, мөн (Их тойруу-4-412а тоот) байршилтай иргэн Сайнхүүгийн Батсүх (ЗИ:92063014)-ийн орон сууцны зориулалттай 250 м² (0.02га) газрыг нэгтгэж одоо байгаа 570 м.кв (0.05га) болгон хэмжээг өөрчилж, үйлчилгээтэй нийтийн орон сууцны зориулалтаар нь 23 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Сайнцагаан сумын Засаг дарга, бөгөөд Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/419 тоот захирамж, 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/420 тоот захирамжийн С.Батсүх-д холбогдох хэсэг, мөн газар эзэмших 0000016068, 0000027366 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100-51